

4/2021


Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 12



Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ Хөвсгөл аймагт хамгийн их буюу 132.0 мянган төгрөг байна.


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 4 дүгээр сард ат 1.2 сая төгрөг болж өмнөх сараас 29.5 мянган төгрөгөөр, хязаалан гуна 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 37.6 мянган төгрөгөөр, соёолон үрээ 946.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 96.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Харин эр хонь 194.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 21.0 мянган төгрөгөөр, эр ямаа 132.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 7.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, 4 дүгээр сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 4 дүгээр сард цагаан ноолуурын 1-кг-ын дундаж үнэ Хөвсгөл аймагт хамгийн их буюу 132.0 мянган төгрөг, Говь-Алтай, Дундговь аймагт хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.

Зураг 2. Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2021 оны 4 дүгээр, төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 4 дүгээр сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 6.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 400 төгрөгөөр өссөн байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 109.5 мянган төгрөг болж өмнөх сараас 4.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Зураг 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 4 дүгээр сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 4 дүгээр сард боодолтой (20кг) өвсний үнэ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 16.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.5 мянган төгрөгөөр өсөж, Дорнод аймагт хамгийн бага буюу 4.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй.

Зураг 4. Боодолтой өвсний дундаж үнэ, 2021 оны 4 дүгээр сард, төгрөгөөр



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 4 дүгээр сард 25кг хивгийн үнэ Хэнтий аймагт хамгийн их буюу 26.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.0 мянган төгрөгөөр өсөж, харин Дундговь аймагт хамгийн бага буюу 16.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Эх үүсвэр: ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 17

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн
газрын гэрээт ажилтан Б. Оргил
Утас : (976-51)-261561*

